



ТӨВ АЙМАГ
БҮРЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 11 өдөр

Дугаар А/75

Бүрэн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2021 оны Ерөнхий боловсролын сургуулийн үдийн цай, дотуур байр, Эрүүл мэндийн төвийн хоол хүнсний нийлүүлэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Отгонхишигт

-Засаг даргын орлогч

Нарийн бичгийн дарга:

Б.Азжаргал

-Ерөнхий боловсролын сургуулийн менежер

Гишүүд:

С.Одгэрэл

-Ерөнхий боловсролын сургуулийн захирал

Н.Энхжаргал

-Нийгмийн бодлогын мэргэжилтэн

Д.Баярсүрэн

-Ерөнхий боловсролын сургуулийн Нярав

2.2021 оны Ерөнхий боловсролын сургуулийн үдийн цай, дотуур байр, Эрүүл мэндийн төвийн хоол хүнсний нийлүүлэгчийг сонгон шалгаруулах ажлыг хуулийн дагуу зохион байгуулж явуулахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Отгонхишигт/-д даалгасугай.

3.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавин, үр дүнг танилцуулж ажиллахыг Санхүү албаны дарга /Ц.Доржпалам/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Т.ТҮВШИНБАТ

410500199